


**БАРИЛГА, ЗАХИАЛАГЧ ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ  
ОНӨААТҮГ**

БАТЛАВ.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,  
ХОГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА *Д. САРАН-ЭРДЭНЭ*



БАРИЛГА, ЗАХИАЛАГЧ ОРОН  
СУУЦНЫ КОРПОРАЦИ ОНӨААТҮГ-Н  
ЗАХИРАЛ *Д. ГАНБАЯР*



**ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН  
БАРИЛГЫН ЗАСВАРЫН АЖИЛ]-ЫН ГҮЙЦЭТГЭГЧ  
ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: БСШУСЯ/202002416**

ТӨВ, ЗУУНМОД ХОТ

2020 ОН

*Ганзориг  
Т.Мамармаа  
2020*

**БАРИЛГА, ЗАХИАЛАГЧ ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ  
ОНӨААТҮГ**

**БАТЛАВ.**

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,  
ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА** **Д. САРАН-ЭРДЭНЭ**

**БАРИЛГА, ЗАХИАЛАГЧ ОРОН  
СУУЦНЫ КОРПОРАЦИ ОНӨААТҮГ-Н  
ЗАХИРАЛ** **Д. ГАНБАЯР**

**[ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН  
БАРИЛГЫН ЗАСВАРЫН АЖИЛ]-ЫН ГҮЙЦЭТГЭГЧ  
ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: БСШУСЯ/202002416**

**ТӨВ, ЗУУНМОД ХОТ**

**2020 ОН**

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020-04-13

**[Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ]** нь тендерт оролцогчдоос **[Төв аймгийн Сэргэлэн сумын цэцэрлэгийн засварын ажил]**-ыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэх **цахим** тендерт урьж байна.

Тендерийн баримт бичгийг, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр Төрийн Худалдан Авах Ажиллагааны Цахим худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) хаягаар өөрийн ААНэгжийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF) файлаар илгээнэ.

Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ **100 mb**, нэг файлын хэмжээ **15 mb**, байна.

Цахим тендер зохион байгуулалт, журмын дагуу тендерт оролцох хураамж **50,000 /тавин мянган/** төгрөгийг ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээр банкны Е-Меркантийн системийг ашиглан төлнө. Үнийн санал ирүүлэх материалын техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 15 цаг 00 минут-аас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)** хаягаар ирүүлсэн байна.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **Зуунмод сумын 6-р /БаруунЗуунмод/ баг Төр, захиргааны 2 дугаар байр 2 давхар 201 тоот өрөө, Худалдан авах ажиллагааны алба 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 15 цаг 30 минут -д** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **“Тооцно”**.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Төв аймаг, Зуунмод сум 6-р баг,  
Орон нутгийн өмчийн газар,  
Аймгийн Төр, Захиргааны 2 дугаар байр, 201 тоот өрөө,  
Утас: 7027-3579,  
Төрийн Худалдан Авах Ажиллагааны Цахим Систем  
[www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
  - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
  - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
  - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
  - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

- 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
  - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
  - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу

гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

## Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа/ТӨӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТӨӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

<b>ТӨӨЗ-ны холбогдох заалт</b>	<b>А. Ерөнхий зүйл</b>
<b>ТӨӨЗ 1.1</b>	Захиалагч нь: <b>[Төв аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци ОНӨААТҮГ]</b>
<b>ТӨӨЗ 1.1</b>	Тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: <b>ажил</b> Тендер шалгаруулалтын дугаар: <b>ТӨАОНӨГ/202002416</b>
	<b>Б. Тендерийн баримт бичиг</b>
<b>ТӨӨЗ 1.1</b>	Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: <b>Төв аймаг, Зуунмод сум, 6-р баг, Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны алба, Утас: 702735-79</b>
<b>ТӨӨЗ 1.1</b>	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын <b>[0]</b> хоногоос багагүй байна.
<b>ТӨӨЗ 1.1</b>	Санхүүжилтийн эх үүсвэр: <b>2020 оны улсын төсвийн эх үүсвэрээр</b> Төсөвт өртөг: <b>40,000,000 төгрөг</b>
	<b>В. Тендер бэлтгэх</b>
<b>ТӨӨЗ 1.1</b>	Хэрэв тендерт гадаадын этгээд оролцох эрхтэй: <b>эрхгүй</b> Тендерийн хэл нь <b>Монгол</b> хэл байна.
<b>ТӨӨЗ 1.3</b>	Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ.Үүнд: Тендерт оролцогч хуулийн этгээд нь 1.1 Үнийн санал /маягтын дагуу/ 1.2 Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар 1.3 Тусгай зөвшөөрөл болон түүний гэрээ, хавсралтын хуулбар /нотариатаар баталгаажуулсан байна. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь “Тусгай зөвшөөрөл олгох асуудал хариуцагч, тусгай зөвшөөрөл эзэмшигч нарын хооронд байгуулсан гэрээний 3.2-т заасан үүргээ биелүүлсэн байна/, - <b>Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар / нотариатаар баталгаажуулсан байх/</b> БА-8.1 Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил 1.4 Монгол улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байх бөгөөд зөвхөн Татварын ерөнхий газрын <a href="http://www.e-tax.mta.mn">www.e-tax.mta.mn</a> сайтыг ашиглан цахим тодорхойлолт авч ирүүлэх ба энэхүү тодорхойлолт нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй байна. 1.5 Монгол улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Харъяа Нийгмийн даатгалын санд өр төлбөргүй тодорхойлолт ирүүлнэ. Тендер нээсэн

өдрийн байдлаар хүчинтэй байна,  
 1.6 Компани сүүлийн 3 жилийн хугацаанд сүүлийн 3 жилийн хугацаанд авилгалын гэмт хэргийн талаар, сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасан эсэх аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээллийг Шүүхийн төрөлжсөн архив, Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолтууд.  
 1.7 Компани хугацаа хэтэрсэн болон зээлийн батлан даалтын гэрээгээр хүлээсэн өр төлбөргүй тухай харилцах банкны тодорхойлолт, /тодорхойлолтыг улсын бүртгэлийн гэрчилгээн дээр бүртгэгдсэн харилцагч банк болгоноос компаниар авч тендерт ирүүлнэ./  
 1.8 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, банк болон дээрх бусад холбогдох байгууллагаас тендерийн бичиг баримттай холбоотой асуудлаар болон нэмэлт тодорхойлолт, лавлагаа гаргуулахад тендерт оролцогч татгалзах зүйлгүй гэсэн мэдэгдлийг тендерийн баримт бичигт хавсарган ирүүлнэ.  
 1.9 Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн *итгэмжлэлийг маягтын* дагуу гаргаж ирүүлнэ.  
 Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь тендерт оролцогчийн үндсэн ажилтан байж, түүнийг ажилд томилсон анхны тушаал, иргэний үнэмлэхийг нотариотаар батлуулсан хуулбарыг ирүүлнэ.

#### ИТГЭМЖЛЭГДСЭН БИЧИГ

Энэхүү тендерийн бичиг баримтад гарын үсэг зурагч \_\_\_\_\_

Компанийн \_\_\_\_\_  
 \_ ажилтай \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_ нь \_\_\_\_\_

\_\_\_\_\_ компанийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах хууль ёсны итгэмжлэгдсэн төлөөлөгч мөн тул \_\_\_\_\_ ын дор зурсан гарын үсгийг баталгаажуулж байна.

\_\_\_\_\_ нь \_\_\_\_\_ компанийг төлөөлж \_\_\_\_\_ компанийн нэр дээр гэрээ, хэлцэл байгуулах, ажил эхэлж дуусгах, гүйцэтгэл гаргах, гологдлыг барагдуулах, албан бичиг баримт явуулах зэрэг сонгон шалгаруулалтад холбогдолтой бүх материалд гарын үсэг зурах эрхтэй болно.

Энэхүү итгэмжлэх бичгийг гэрчилж 2020 оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_ ны өдөр гарын үсэг зурав.

Тэмдэг

Байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн

Овог, нэр \_\_\_\_\_

Гарын үсэг \_\_\_\_\_

Баталгаажуулагчийн

Овог, нэр \_\_\_\_\_

Гарын үсэг \_\_\_\_\_



Дээрх тодорхойлолтууд нь зөвхөн захиалагчид хаяглагдсан байх бөгөөд эрх бүхий байгууллагаас олгосон хугацаа заагаагүй тодорхойлолтын хувьд 30 хоногийн хугацаанд хүчинтэй гэж үзнэ.

Монгол улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлсөн эсэхийг тендер нээсэн өдрөөр тооцно.

1.10 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр ирүүлэх. /Тендерт оролцогч нь үнэлгээний хорооны гишүүдэд нөлөөлөх, эрх бүхий албан тушаалтнаар дамжуулан нөлөөлөхийг оролдсон нь баримтаар нотлогдвол тендерээс татгалзана./

1.11 Сүүлийн 2 жил / 2018, 2019 он/-д нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээ чанартай, холбогдох стандартыг хангаж байгаа талаар өмнөх захиалагч байгууллагуудын тодорхойлолт, гэрээ дүгнэсэн актыг ирүүлнэ. Өмнөх үйлчлүүлэгч, захиалагчтай холбогдох утас, мэйл хаягийг жагсаалтаар ирүүлсэн байна./

№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас/факс	Төсөвт өртөг	Дууссан, эсхүл дуусах хугацаа
1				
	Дүн			

1.12 Тендерт оролцогч нь тендер нээсэн өдрийн байдлаар гэрээ хэрэгжүүлж байгаа болон гэрээ байгуулах эрх авсан талаарх мэдээллийг албан бичгээр гаргаж ирүүлэх үүрэгтэй.

1.13 Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан ажлын даалгавар зураг, төсвийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн бараа, ажил, үйлчилгээг дуусгаж ашиглалтанд хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.

1.14 Тендерт оролцогч нь Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолд тусгагдсан “Дотоодод үйлдвэрлэсэн чанар стандартын шаардлага хангасан бараа”-ны жагсаалтад тусгагдсан барааг барилгын ажилд ашиглах бол тухайн барааны нэр төрөл, тоо хэмжээ, төсөвт өртөг, барааны гарал үүслийн талаарх мэдээллийг, дотоодод үйлдвэрлэгдсэн бараа, бүтээгдэхүүн ашиглахгүй бол тэр талаарх мэдэгдэлийг тус тус ирүүлнэ.

1.15 Тендерт оролцогч нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолгүй тухай мэдэгдэл ирүүлнэ

ТШӨХ-н 1.1-д заасан өгөгдөл, шаардлагын аль нэгийг хангаагүй эсхүл дээр заасан тодорхойлолтууд, баримт бичгүүдээс аль нэгийг нь ирүүлээгүй, ирүүлсэн баримт бичиг нь заасан нөхцөл, шалгуурыг хангахгүй, хуурамч, эсхүл сүүлийн 3 жилд нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээний чанар хангалтгүй байсан нь өмнөх захиалагч байгууллагуудын тодорхойлолтоор болон хяналт шалгалтын байгууллагын хяналтаар нотлогдсон зэрэг тохиолдолд тендерээс татгалзаж, хуурамч нотлох баримт ирүүлсэн нь нотлогдсон нөхцөлд тендерт орох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгүүлэхээр эрх бүхий байгууллагад хандана.

**ТӨӨЗ 1.3**

Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудад гүйцэтгэсэн барилга угсралтын

ажил, тэдгээрийн гэрээний үнийг жил жилээр харуулсан мэдээллийг ижил төстэй ажилд тооцуулахаар доорх хүснэгтээр ирүүлэх:

№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас/факс	Төсөвт өртөг	Дууссан, эсхүл дуусах хугацаа
1				
....				
	ДҮН			

1.Сүүлийн 2 /2018, 2019 он/ хугацаанд доод тал нь нэг удаа тендерт санал болгож буй барилга угсралт, засвар, шинэчлэлийн ажилтай ижил, төстэй ажлыг гүйцэтгэх гэрээний ерөнхий гүйцэтгэгчээр ажилласан туршлагатай байх ба энэхүү гэрээ (ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн тэр гэрээ)-ний үнэ нь энэ тендерт санал болгож буй ажлын төсөвт өртгийн 100 хувиас багагүй байж, нотлох баримтыг ирүүлнэ.

2. Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудад гэрээгээр гүйцэтгэсэн барилга угсралтын ажлыг ижил төстэй ажилд тооцуулах ажлын жагсаалт, ажил тус бүрийн гэрээний эх хувиас татсан хуулбар,гэрээ дүгнэсэн акт, гэрээ бүрийн гүйцэтгэл бүрэн, чанартай байсан талаар өмнөх захиалагчийн тодорхойлолтыг ирүүлэх, ажлыг ашиглалтад оруулах Улсын комиссын акт зэрэг баримт бичгийн хуулбарыг нотариатаар баталгаажуулж, PDF хэлбэрт шилжүүлэн ирүүлнэ. Барилга байгууламжийн ажлын захиалагч нь орон нутгийн төсвийн хөрөнгөөр ажил гүйцэтгүүлсэн бол захиалагч байгууллагаар томилогдсон байгууллага эсхүл аймаг, сумын Засаг даргын тамгын газраас олгосон тодорхойлолтын аль нэгийг, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ажил гүйцэтгэсэн тохиолдолд захиалагч байгууллагын тодорхойлолтыг, хувийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн тохиолдолд үндсэн захиалагч байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ.

3. Ижил төстэй ажилд зөвхөн барилгын засвар, шинэчлэлийн ажлыг тооцно.

<b>ТӨӨЗ 1.3</b>	<p>Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: <b>“Шаардлагатай” 2018,2019 онуудын санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт ирүүлнэ .</b></p> <p><b>2018, 2019 онуудын борлуулалтын орлогын дундаж нь төсөвт өртгийн 100 хувиас багагүй байна.</b></p> <p><b>2018, 2019 оны санхүүгийн тайлан сангийн яамны e-balance цахим бүртгэлд шивэгдэж баталгаажсан байх шаардлагатай, санхүүгийн тайлан бүртгэлд шивэгдээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</b></p>
<b>ТӨӨЗ 1.3</b>	<p>Гэрээг гүйцэтгэхээд зайлшгүй шаардлагатай ажиллах хүч: Мэргэжилтэй ажилчдын диплом, мэргэжлийн үнэмлэхийн хуулбарыг ирүүлнэ.</p> <p>Барилгын ерөнхий инженер тухайн байгууллагын үндсэн ажилчин байх бөгөөд ажилладаг талаар нотлох нийгмийн даатгалын дэвтрийн хуулбарыг хамт ирүүлнэ.</p>
<b>ТӨӨЗ 1.3</b>	<p>Гэрээт ажилд ашиглах өөрийн эзэмшлийн машин механизм, тоног</p>

төхөөрөмжийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлнэ. Гэрээт ажилд ашиглах машин механизм, тоног төхөөрөмжийн жагсаалтыг маягт энэхүү дагуу ирүүлнэ.					
<b>д/д</b>	Машин механизм, тоног төхөөрөмж, ажлын багаж хэрэгслийн нэр, марк	Тодорхойлолт, хаана үйлдвэрлэсэн, ашиглагдсан хугацаа /жилээр/	Хүчин чадал, тоо ширхэг	Ашиглалтын байдал (шинэ, сайн, хуучин), хэдэн оноос ашиглаж байгаа	Өөрийн, түрээслэх, эсхүл худалдаж авах
А. Үндсэн тоног тө-хөөрөмж, багаж хэрэгсэл					
1					
2					
3					
4					
Б. Хяналт, шалгалтын багаж хэрэгсэл					
1					
2					
3					
<b>ТӨӨЗ 1.3</b>	Одоогийн ба сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээллийг маягтаар ирүүлнэ.				
	Нөгөө тал /ууд/	Маргааны шалтгаан	Нэхэмжлэлийн мөнгөн дүн	Шийдэгдсэн байдал	
	А)				
	Б)				
<b>ТӨӨЗ 1.3</b>	<p>Тендерт оролцогч дараах нэмэлт материалуудыг захиалагчид хаяглан өөрийн тендерт ирүүлнэ.Үүнд:</p> <p><b>ТӨӨЗ 14.1 (ж)-ын 1.</b> Доорхи захиалагчийн хяналтын зардал, зураг төсвийн үнэ, зохиогчийн хяналтын зардал, магадлашгүй ажлын зардал, норм нормативын сан зэргийг тендерт оролцогч өөрийн төсөвт оруулж тусгана.</p> <p><b>Үүнд:</b></p> <p><b>-Захиалагчийн хяналтын зардал:</b> Зураг, төсвийг норм дүрмийн дагуу тооцож, санал болгож буй өртгийн төсөвт тусгаж ирүүлнэ.</p> <p><b>-Зураг, төсвийн үнэ- 0 төгрөг.</b></p> <p><b>Зохиогчийн хяналтын зардал:</b> Уг зардлыг зураг, төсвийн норм дүрмийн дагуу тооцож, санал болгож буй өртгийн төсөвт тооцож ирүүлнэ.</p> <p><b>-Магадлашгүй ажлын зардал:</b> Уг зардлыг зураг, төсвийн норм дүрмийн дагуу тооцож санал болгож буй өртгийн төсөвт тооцож ирүүлнэ.</p> <p><b>-Норм, нормативын сан:</b> Уг зардлыг зураг, төсвийн норм дүрмийн дагуу санал болгож буй төсөвт тооцож ирүүлнэ.</p>				

**Тендерт оролцогч нь дээр заасан захиалагчийн хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал, нормчлолын сангийн шимтгэл, магадлашгүй ажлын зардал зэргийг зураг, төсвийн норм дүрмийн дагуу тооцож, санал болгож буй төсөвтөө тусгаж ирүүлэх ба дээрх зардлыг тооцохдоо барилгын зураг төсөл зохиох норм дүрмийн дагуу тооцох хэмжээнээс багаар тооцож ирүүлсэн тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.**

**ТӨӨЗ 14.1 (ж)-ын 2.** Барилгын ажилд ашиглахаар санал болгож буй материал нь Монгол улсад болон олон улсад мөрдөгдөж байгаа стандарт хангасан болохыг нотлох техникийн тодорхойлолтыг бэлтгэж, холбогдох тайлбар үндэслэлийг тендерт оролцогчийн эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулж, төслийн менежерт ирүүлэх ба энэ нь гэрээний салшгүй хэсэг болно.

**ТӨӨЗ 14.1 (ж)-ын 3.** Ажил гүйцэтгэх нарийвчилсан хугацааны графикийг /маягт №ТШМ-2-1 дагуу/ ирүүлнэ. Мөн аргачлалыг зургийн тайлбартай уялдуулан боловсруулж, талбай дээрхи нэгжийн бүтэц зохион байгуулалтын хамт ирүүлнэ.

**ТӨӨЗ 14.1 (ж)-ын 4.** Тендерийн баримт бичигт хавсаргасан хяналтын төсвийн ажлын тоо хэмжээг үндэслэн өөрийн ажлын төсөвт өртгийн тооцооллыг ирүүлэх ба хяналтын төсвийн тоо хэмжээгээр тендерт оролцогчийн үнийн санал, материалын үнэ зэргийг зах зээлийн бодит үнэтэй хянаж үнэлнэ.

Ажлын тоо хэмжээний дагуу тооцсон өртөгийн төсвийг, эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна /төсвийг ЗТБХБ-ын сайдын 2012 оны 181-р тушаалаар батлагдсан төсөв зохиох дүрмийн дагуу алдаагүй тооцож, Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсөв зохиох программаар алдаагүй хийж гүйцэтгэсэн байна.

Төсөв зохиосон төсөвчний эрх бүхий гэдгийг нотлох холбогдох байгууллагаас олгсон гэрчилгээг эх хувиас хуулбарлан ирүүлнэ.

**ТӨӨЗ 14.1 (ж)-ын 5.** Тендерт санал болгож буй үнийн дүн нь зураг, ажлын тоо хэмжээний дагуу боловсруулсан төсвийн дүнтэй ижил байна.

**ТӨӨЗ 14.1 (ж)-ын 6.** Үнийн саналыг Маягтын дагуу ирүүлнэ.

**ТӨӨЗ 14.1 (ж)-ын 7.** ТБОНӨХБАҮХАТХ 14.1.1-14.1.7-д заасан нөхцөл үүсээгүй мэдэгдэл

**ТӨӨЗ 14.1 (ж)-ын 8.** Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан ажлын зураг, төсөв БНбаДүрмийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн бараа, ажил, үйлчилгээг дуусгаж ашиглалтанд хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.

**ТӨӨЗ 14.1 (ж)-ын 9.** Санхүүжилтийн хуваарийг маягт №ТШМ 2-2 маягтаар гаргаж, баталгаажуулан ирүүлнэ.

**ТӨӨЗ 14.1 (ж)-ын 10.** Тендерийн баримт бичигт заагдсан гэрээний Ерөнхий болон Тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ.

**ТӨӨЗ 14.1 (ж)-ын 11.** Тендерт оролцогчийн ирүүлсэн тендерийн баримт бичиг, үнийн саналыг олон нийтэд мэдээллэхэд татгалзахгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдлийг бүрэн ирүүлнэ.

**ТӨӨЗ 14.1 (ж)-ын 12.** Барилга угсралтын болон их засвар, засварын ажилд шаардагдах үндсэн тоног төхөөрөмж, техник, багаж хэрэгслийг цаг

хугацаанд нь бэлэн байлгах тухай мэдэгдэл ирүүлнэ.  
**ТӨӨЗ 14.1 (ж)-ын 13.** Тендерт оролцогч нь ажлын талбай, түүний байршил, орчны нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж судлан тендер бэлтгэсэн талаарх албан мэдэгдлийг газар дээр нь танилцсан фото зургийн хамт ирүүлнэ.

**ТӨӨЗ 14.1 (ж)-ын 14.** Барилгын ажилд хэрэглэх импортын материал болон тоног төхөөрөмжийг Монгол Улсад үйлдвэрлэсэн материалаас тусад нь багцалж дараах хүснэгтээр ирүүлнэ. Үүнд:

№	Барилгын материалын нэр, загвар, марк	Барилгын материалын техникийн тодорхойлолт, холбогдох стандарт	Хэмжих нэгж	Тоо	Нэгж үнэ /төгрөг/	Бүгд үнэ /төгрөг/
1	2	3	4	5	6	7
<b>Нийт үнэ /төгрөг/</b>						

**ТШӨХ-ийн ТӨӨЗ 14.1 (ж)-д заасан өгөгдөл, шаардлагын аль нэгийг хангаагүй, ирүүлэхээр заасан баримт материалын бүрдэл дутуу, шаардлагын хэмжээнд боловсруулагдаагүй, буруу маягт болон буруу тооцогдож ирсэн бол тухайн тендерээс татгалзана.**

- ТӨӨЗ 1.4** Тендер ирүүлэхийн өмнө уулзалт зохион байгуулах эсэх: **“Үгүй”**
- ТӨӨЗ 1.5** Хувилбарт тендер ирүүлэхийг **“Зөвшөөрөхгүй”**
- ТӨӨЗ 1.6** Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад **“Тохируулахгүй тогтмол байна”**
- ТӨӨЗ 1.7** Тендерийн валют **“Төгрөг байна.”**  
**Урьдчилгаа төлбөр төлөхгүй.**
- ТӨӨЗ 1.8** Тендер нээснээс хойш **30 хоногийн** туршид хүчинтэй байна.
- ТӨӨЗ 1.9** Тендерийн баталгааны дүн: **“Шаардахгүй”**
- ТӨӨЗ 1.10** Тендерийн эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувийн тоо: **шаардлагагүй**

**Г. Тендер ирүүлэх**

**ТӨӨЗ 2.1** Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь:  
Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн цахим хэлбэрт оруулж ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод, уншигдахуйц, бичиг хэргийн стандарт шаардлага хангасан байх шаардлагатай.  
Хэрэв тод биш, уншигдахааргүй тендерийн материал ирүүлсэн бол иж бүрдэл дутуу гэж үзэн тухайн тендерээс татгалзах үндэслэл болно  
Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ форматад хөрвүүлэн, өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсгээр цахим хэлбэрээр ирүүлнэ.  
Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) –д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг (PKI)-ээр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.  
**Тендерт оролцогчийн цахим системээр ирүүлж оролцсон ТӨӨЗ**

	<p><b>болон ТШӨХ-д заасан тендерийн баримт бичгийг бэлтгэн ирүүлсэн тендерийн материал нь тендерт оролцогчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн нууц үгтэй улмаас нээгдэхгүй /Adobe PDF/ форматад хөрвүүлсэн файл уншигдахгүй тохиолдолд үнэлгээнд харгалзан үзэхгүй, татгалзах үндэслэл болно</b></p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: <b>2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр</b> Цаг: <b>[15 цаг 00 минут]</b> <b>Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй.</b></p>
	<b>Д. Тендерийг нээх, үнэлэх</b>
<b>ТӨӨЗ 2.1</b>	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: Байшин, гудамжны нэр: <b>Төв аймаг Зуунмод сум Төр, Захиргааны 2 дугаар байр, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны алба</b> Давхар болон өрөөний дугаар: <b>2 давхарт, 201 тоот өрөө</b> Аймаг, хот: <b>Төв аймаг Зуунмод хот</b> Улс: <b>Монгол Улс</b> Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: <b>2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр</b> Цаг: <b>[15 цаг 30 минут]</b></p>
<b>ТӨӨЗ 2.2.3</b>	<p>Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж/ <b>файл</b> үүсгэж ирүүлнэ. Тус хавтасны/ файлын эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна.</p> <p>Нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулаагүй бол нууцлахгүй ирүүлэх материал гэж үзнэ.</p> <p>Нууцлахгүй ирүүлэхээр шаардсан материалыг худалдан авах ажиллагааны цахим системд “нууц эсэх- тийм” байхаар ирүүлсэн тохиолдолд тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
	<b>Е. Гэрээ байгуулах эрх олгох</b>

## Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Ажлын хяналтын төсвийг цахим системийн ТЭЗҮ хэсэгт нийтэлсэн болно.

Тав. ЗУРАГ

**Зургийн санамж**

Энд зургуудыг жагсааж бичнэ. Зураг, түүний дотор ажлын талбайн зургийг энэ бүлэгт, эсхүл тусад нь хавтсанд хийж хавсаргана.

**Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ**

**Ажлын барилга угсралт/ засварын ажлын үе шатны хуваарийн маягт /Маягт №ТШМ-2-2/**

д/д	Хийгдэх ажил	Сар	2020 оны ,,-р сар			,,,-р сар			2020 оны 12-р сар			Дүн /төгрөгөөр/
			10 хоног	1	2	3	1	2	3	1	2	
1		Төлөвлөгөө		Мөнгөн дүнгээр								
		гүйцэтгэл										
		Төлөвлөгөө										
		гүйцэтгэл										
		Төлөвлөгөө										
		гүйцэтгэл										
		Төлөвлөгөө										
		гүйцэтгэл										
	Захиалагчийн хяналтын зардал	Төлөвлөгөө										
		гүйцэтгэл										
	Зохиогчийн хяналтын зардал	Төлөвлөгөө										
		гүйцэтгэл										
	Магадлашгүй ажил	Төлөвлөгөө										
		гүйцэтгэл										
	Улсын комисст хүлээлгэн өгөх	Төлөвлөгөө							2020.08.25			
		гүйцэтгэл										
<b>Бүгд дүн /сая,төг/</b>												<b>Санал болгож буй тендерийн үнэ бичигдэнэ.</b>

**Тайлбар:** дээрхи Маягт №ТШМ-2-2 дагуу ажлын үе шатны хуваарийг боловсруулж ирүүлэх бөгөөд ажлын үе шатны хуваарийг барилга угсралтын ажил тус бүрээр мөнгөн дүнгээр боловсруулах, барилгын ажлыг **2020 оны 06 сарын 15-ны дотор** ашиглалтанд оруулна.



**Санхүүжилтийн хуваарийн /Маягт №ТШМ-2-2/**

д/д	Ажлын нэр	Гэрээний дүн /төгрөгөөр/	2020-2020 он					Дүн
			5 сар	6 сар	....	....	12 сар	
1								-
2								-
3								-
4								-
5								-
6								-
7								-
8								-
г.м								-
15	Захиалагчийн хяналтын зардал							-
16	Зохиогчийн хяналтын зардал							-
17	Магадлашгүй ажил							-
Ажлын гүйцэтгэл /хувиар/								-
Санхүүжилтийн дүн /хувиар/								-
	Санхүүжилтийн нийт дүн /төгрөгөөр/							<b>Санал болгож буй тендерийн үнэ бичигдэнэ.</b>

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**  
ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                         | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.  |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                        | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.   |
| <b>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b> | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.  |
| <b>4. Аюулгүй байдал</b>                                    | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br><br>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.   |
| <b>5. Зааварчилгаа</b>                                      | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй  |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>                              | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |
| <b>7. Ажлын хөтөлбөр</b>                                    | <b>Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ</b><br>7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.<br><br>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| <b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b>                         | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж  |

шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.

- 9. Зөрчил, гологдол арилгах**
- 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа<sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

## **В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ**

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги<sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

## **Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.

<sup>1</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

<sup>2</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- 15. Хүлээж авах** 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо** 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага** 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах** 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
  - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
  - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
  - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил,

гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;

(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

**19. Гэрээг  
цуцалсан  
үед хийх  
төлбөр**

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**20. Гүйцэтгэлэ  
эс  
чөлөөлөх**

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

### Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ<sup>3</sup>

<b>ГЕН 2.1</b>	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <b>[ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГЫН ЗАСВАРЫН АЖИЛ БСШУСЯ/202002416]</b>
<b>ГЕН 2.1</b>	Ажил нь <b>[ цахим системд нийтэлсэн хяналтын төсөвт ]</b> -аас бүрдэнэ.  Ажлын талбай нь <b>[Төв аймгийн Сэргэлэн суманд ]</b> -д байрших ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно.
<b>ГЕН 3.1</b>	Төслийн менежер нь <b>[захиалагч байгууллагаас томилогдсон этгээд байна. ]</b>
<b>ГЕН 4.1</b>	Ажил эхлэх өдөр <b>[2020.05.01]</b> Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <b>[2020.06.15]</b> <sup>4</sup>
<b>ГЕН 7.1</b>	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <b>[5]</b> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
<b>ГЕН 9.1</b>	Чанарын баталгаат хугацаа <b>[.....]</b> хоног байна.
<b>ГЕН 13.1</b>	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <b>[0,05]</b> байна. <sup>5</sup>  Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <b>[10]</b> байна.
<b>ГЕН 17.1</b>	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <b>[огноо]</b> -ны дотор гаргаж өгнө.  Гүйцэтгэлийн зургийг <b>[огноо]</b> -ны дотор гаргаж өгнө.  Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ <b>[мөнгөн дүн]</b> байна.
<b>ГЕН 19.1</b>	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <b>[хувь]</b> -иар тооцно.

<sup>3</sup> Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

<sup>4</sup> Ажлыг хэсэгчлэн дуусгахаар төлөвлөсөн бол эдгээр хугацааг жагсаана.

<sup>5</sup> Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

### ЗАХИАЛАГЧ

### ГҮЙЦЭТГЭГЧ

_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....  
хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны



\_\_\_ дугаар сарын \_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_ дугаар сарын \_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

#### **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын  
үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

#### **ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын  
үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]